

“ЯПОНЫ ТУХАЙ МИНИЙ ДУРСАМЖ” ГЭРЭЛ ЗУРГИЙН

ГУРАВДУГААР УРАЛДААН

ДҮРЭМ

1. Хэн оролцох эрхтэй вэ?

Гэрэл зургийн энэхүү уралдаанд зөвхөн Монгол улсын иргэн оролцох боломжтой. Бүртгэл эхлэх үед оролцогч нь Монгол буюу Япон улсын аль нэгэнд оршин сууж байвал зохино.

2. Гэрэл зурагт тавих шаардлага

- (1) Нэг оролцогч дээд тал нь 2 гэрэл зургаар оролцоно.
- (2) Уралдаанд ирүүлэх гэрэл зургууд зөвхөн дижитал хэлбэртэй байх бөгөөд бүх файлууд нь 20MB буюу түүнээс бага хэмжээтэй, JPEG буюу .jpg өргөтгөлтэй, доод тал нь 1600 пиксель өргөн (хөндлөн зураг бол) буюу 1600 пиксель өндөр (босоо зураг бол)-тэй байна. Негатив болон гэрэл зургийн сканердсан хувилбар байж болох ч хэвлэмэл гэрэл зураг болон хальсыг хүлээн авахгүй.
- (3) Гэрэл зургууд нь өмнө нь аливаа уралдаанд оролцон шагнал хүртэж байгаагүй, өмнөх жилүүдийн “Японы тухай миний дурсамж” гэрэл зургийн уралдаанд оролцож байгаагүй байна.
- (4) Зөвхөн бага зэргийн засвар (burning, dodging г.м.), тайралт болон өнгөний тохиргоо хийхийг зөвшөөрнө. HDR болон залгасан панорама зураг байж болно.
- (5) Зохиогчийн эрхийг зөрчөөгүй, хуульд нийцсэн тохиолдолд баримал, хөшөө, уран зураг болон бусад төрлийн соёл урлагийн бүтээлүүдийг харуулсан гэрэл зургийг ирүүлж болно. Бусдын бүтээлийг харуулсан гэрэл зураг нь “full-frame close-up” зураг бус, хүрээлэн буй орчныг нь багтаасан байна.
- (6) Гэрэл зураг нь бусдын нүүр царайг тод тусгасан тохиолдолд тухайн хүний эрх зөрчигдөөгүй, зохих зөвшөөрөл авсныг ЭСЯ-нд нотолно

(7) Гэрэл зураг нь бүхэлдээ оролцогчийн өөрийн авсан дан гац бүтээлийн эх хувь байна. Уралдаанд бүртгүүлснээрээ уг бүтээл нь оролцогчийн өөрийн авсан бүтээлийн эх хувь болохыг нотлон баталгаажуулсан, уг бүтээл нь аливаа зохиогчийн эрх, худалдааны тэмдэгт, ёс суртахууны эрх, хувь хүн буюу олон нийтийн эрх, аливаа хувь хүн болоод хуулийн этгээдийн оюуны өмчийн эрхийг зөрчөөгүйг, мөн хэн нэгэн уг гэрэл зурагтай холбоо бүхий эрх эдэлдэггүй, аливаа ашиг сонирхол үгүйг нотолсон хэмээн үзнэ.

(8) Усан тэмдэгт байхыг зөвшөөрөхгүй.

3. Шүүлт

Уралдаанд ирүүлсэн бүтээл (гэрэл зураг) бүрийг бусдаас тусад нь шүүнэ. Японы ЭСЯ болон хамтран зохион байгуулагчдын төлөөлөл Уралдааны болзол хангасан гэрэл зургуудаас сонгон 1, 2, 3 болон тусгай байрны шагналтнуудыг шалгаруулна. Шалгарсан оролцогчдод цахим шуудангаар мэдэгдэнэ. Шүүгчдийн шийдвэр эцсийнх байх болно.

4. Зөвшөөрөл

Уралдаанд оролцсоноор оролцогч нь өөрийн бүтээлийг (нэрийн хамтаар) хэвлэл мэдээллийн аль ч хэрэгсэлд хэвлэн нийтлэх, түүгээр дамжуулан түгээх, нийтэд толилуулах, дайвар бүтээл туурвих эрхийг эргэлт буцалтгүй, хугацаагүй, үнэ төлбөргүй, онцгой бус нөхцөлөөр Японы ЭСЯ-нд олгох бөгөөд үүнд:

- Японы ЭСЯ-наас зохиох үзэсгэлэн, үзвэр (“Японы тухай миний дурсамж” нэртэй үзэсгэлэн г.м.);
- Японы ЭСЯ-наас гаргах эмхтгэл, товхимол, сурталчилгааны хуудас болон видео материал;
- Вэб хуудас, Facebook зэрэг интернэт орчинд үйл ажиллагаа явуулдаг хэрэгслүүд багтана.

5. Мэдээллийн нууцлал

Оролцогч нь Уралдааны хүрээнд болон энэхүү дүрэмд заасан зорилгод

нийцүүлэн өөрийн хувийн мэдээлэл, ялангуяа нэр болон хаягийг боловсруулах, хуваалцах зэрэг хэлбэрээр ашиглахыг зөвшөөрнө. Түүнчлэн оролцогчийн нэр, шуудангийн хаяг, утасны дугаарыг тодруулах, мөн Японы ЭСЯ-наас Уралдаанд оролцох эрхийг баталгаажуулах зорилгоор уг мэдээллийг ашиглаж болно. Оролцогч нь бичгээр хүсэлт тавин Японы ЭСЯ-ны мэдэлд буй өөрийн мэдээллийг үзэх, шалгах, засварлах буюу устгуулах эрхтэй болно. Японы ЭСЯ болон түүнтэй холбогдох байгууллагууд нь хувийн мэдээллийг зөвхөн энд заасан зорилгоор ашиглана.